



**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын  
үйл ажиллагааны тайлан**

**2014 он**

**Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг  
Ажлын алба**

## **АГУУЛГА**

**Нэг.** 2014 оны хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тухай;

**Хоёр.** ОУИТБС-ын шаардлага бүрийг хангасан байдал, явц;

**Гурав.** Баталгаажуулалтын зөвлөмжийн дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний тойм;

**Дөрөв.** Ажлын төлөвлөгөөний биелэлтийн байдал, биелсэн зорилтуудын ач холбогдол;

**Тав.** Цаашид хэрэгжүүлэх ажлын томъёолол, оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх тухай;

**Зургаа.** Тайланг боловсруулсан, баталсан огноо;

## **НЭГ. 2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮНГИЙН ТУХАЙ**

### **1.1. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаануудын тойм**

#### **Үндэсний зөвлөл**

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг Засгийн газар огцорсон, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга ажиллах боломжгүй болсон зэрэг шалтгааны улмаас хуралдуулж чадаагүй болно.

#### **Ажлын хэсэг**

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий олон талт Ажлын хэсэг 2014 оны 3 дугаар сард 1 удаа, 10 дугаар сард 1 удаа, бүгд 2 удаа хуралдав. Хуралдаан бүрийн шийдвэрийг сийрүүлэв. Үүнд:

#### **2014 оны 3 дугаар сарын 11-ний өдөр**

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монголын АйСиЖи компаниас боловсруулсан Монголын ОУИТБС-ын стратеги төлөвлөгөө, түүний ажлыг төлөвлөгөөг дэмжин хүлээн авч хэрэгжүүлэхийн төлөө талууд хамтарч ажиллахаар тогтов.
2. Засгийн газар крмпаниудын тайлагналын явцыг ажлын хэсэг сонсож танилцлаа. Тайлагналын явцын тухай мэдээллийг хэвлэл мэдээлэлд нийтлүүлэхийг ажлын албанд даалгав. Холбогдох мэдээллийг сонинд тавьж нийтэд мэдээлсэн байна.
3. Ажлын хэсгийн гишүүдийн санал дүгнэлтийг тусган шинэчлэн найруулахаар тогтов.
4. Үнэт цаасны тухай хуулийн 4.1.26-д “бенефициар өмчлөгч” гэж зааснаар тогтов.
5. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай ажиллаж буй төр, засгийн байгууллагад гурван зуун мянган төгрөг, иргэний нийгмийн байгууллагуудад долоон зуун мянган төгрөг, ажлын албанд гурван зуун арван зургаан мянга гурван зуун төгрөгийг урамшуулал болгон тус тус олгосугай.

#### **2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр**

Хэлэлцсэн асуудал ба шийдвэрүүдийг сийрүүлэв. Үүнд:

1. Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан, дунд тайлантай танилцаж хангалттай гэж үзэв.
2. Тайлангийн шийдэгдээгүй зөрүү бүхнийг дахин нягталж, шийдвэрлэх талаар ажиллаж, Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг тусган эцэслэн боловсруулж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Улаанбаатар аудит корпорацид үүрэг болгов.
3. Үндэсний зөвлөлийн хуралдааныг энэ оны 11 дүгээр сарын сүүлчээр зохион байгуулахыг Ажлын албанд даалгав.
4. Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн гэрээт үнийн дүнгийн 80 хувийн төлбөрийг Улаанбаатар аудит корпораци ХХк, Харт Нойрс лтд компанийн хамтарсан консерциумд төлж барагдуулахыг Ажлын албанд зөвшөөрөв.

5. ТАН эвслийн хэрэгжүүлсэн мониторингуудын болон ББЗХ-ийн хийсэн судалгааны дүгнэлт, зөвлөмжүүдийн мөрөөр авах арга хэмжээг хэрэгжүүлэх санал боловсруулах, холбогдох журамд өөрчлөлт оруулах үүрэг бүхий цомхон ажлын баг бүрдүүлж, 10 дугаар сарын 24-ны өдрийн дотор томилохыг Ажлын хэсгийн ахлагчид даалгав.
6. Дээрх ажлын баг нь жил бүрийн Үндэсний нэгтгэл тайлангаар өгөгдөж буй зөвлөмжийг хэрэгжүүлэх санал боловсруулах, өмнөх тайлангуудаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн, шаардлагатай арга хэмжээ авах тухай шийдвэрийн төслийг боловсруулан Ажлын хэсгийн болон Үндэсний зөвлөлийн хуралдаанд тогтмол танилцуулж байхыг Ажлын албанд даалгав.
7. Ажлын хэсгийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийн явцын талаар дараагийн Ажлын хэсгийн хуралдаанд тогтмол танилцуулж байхыг ажлын албанд даалгав.
8. ЕСБХС-наас санхүүжүүлэн Адам Смит Интернэйшнл байгууллагаас зохион байгуулж буй туршлага судлах аялалын бүрэлдэхүүнийг талуудын тэнцүү төлөөлөлтэй байхаар шийдвэрлэв.

## **1.2. Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн тойм**

Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэлийг хийж гүйцэтгэхээр Их Британийн Харт Нойрс, Монголын Улаанбаатар аудит корпорац ХХК-иудын консерцум шалгарч, гэрээт ажлаа 2014 оны 7 дугаар сарын сүүлчээр эхлүүлсэн.

Энэ нэгтгэлд 250 компанийн төлбөр, тэднээс Засгийн газрын хүлээн авсан орлогын аудитын нэгтгэлийг явуулж, 2014 оны 12 дүгээр сарын эхээр дуусгаж, Ажлын хэсгээр 1 удаа, 10 дугаар сард хэлэлцүүлж, Үндэсний зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 13-ны хурлаар хэлэлцэхээр тогтов.

### **Ерөнхий хэсэг**

2013 онд олборлох салбар нь Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 18,5%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 58,7%, экспортын 90%-ийг бүрдүүлсэн байна.

2013 онд Монгол Улсын нийт 1,103,6 мянган хөдөлмөр эрхлэгчдийн 50,3 мянга нь уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 5% нь болж байна. Энэхүү тайлангаар нэгтгэлд орсон компаниуд нь 181 нь ажиллагсдынхаа талаар мэдээлэл өгсөн байна. Нийт 24,7 мянган хүн ажилладаг гэж мэдүүсний 2,5 мянга нь гадаадын ажиллагсад байжээ.

Нийт 250 компанийн нэгтгэгдсэн дүн болох 1576 тэрбум төгрөг нь 2013 оны улсын төсвийн урсгал орлого - 5879 тэрбум төгрөгийн 27 хувийг бүрдүүлжээ. Энэхүү тайлан нь олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан орлогыг Сангийн яам 1617 компани, 1683,6 тэрбум төгрөг гэж тайлагнасны 92 хувийг хамарсан байна. Орон нутагт хүлээн авсан орлогын хэмжээ 107,7 тэрбум төгрөг буюу 2012 оны орлогоос 15,3 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хандив дэмжлэг 2012 оны тайлангаар 13,1 тэрбум төгрөгөөр нотлогдсон бол 2013 онд 39,2 тэрбум төгрөг бараг 3 дахин нэмэгдсэн байна.

Тайлбарлагдаагүй зөрүүний хэмжээ 37 сая төгрөг байгааг уг мэргэжлийн байгууллага нотолж, харин материаллаг бус гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Олборлох үйлдвэрлэлд газрын тосны 17 компани буюу 21 бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 14 компани буюу 68 тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, бусад ашигтмалын хайгуул, ашиглалтын 1660 компани буюу 1300

ашиглалт, 1729 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд 2013 оны эцсийн дүнгээр ажиллаж байв. Олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 2005 онд 4955 байсан 8 жилийн дараа 1815 болж буурсан бол харин 2005 онд ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 958- ийг олгосон байсан нь 2013 онд 1303 болж нэмэгджээ.

Тэргүүлэх 4 компани буюу Эрдэнэт, Оюутолгой, Петрочайне Дачин Тамсаг, МАК компаниуд нь нийт 1,06 их наяд орлогын татвар буюу 62,7 хувийг эзэлж байна. Экспортын орлогын 52 хувийг зэс молибден, 22 хувийг нүүрс, 12 хувийг газрын тос тус тус бүрдүүлсэн байна.

Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголт, Монгол улсын эдийн засагт олборлох үйлдвэрлэлээс оруулж буй хувь нэмэр, төсвийн орлого, хуваарилалт, зарцуулалт, тусгай сангуудын орлого, зарлага, дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон бараа материалын солилцоо, хандив дэмжлэг, давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн талаархи мэдээлэл хэвлэн нийтлүүлэх ОУИТБС- ын стандартын шаардлагууд Монгол Улсад ямар түвшинд байгааг дүгнэж, холбогдох судалгааг гаргасан байна.

Тайлангуудын баталгаажуулалтын хувьд зөвхөн 10 компани ОУИТБС- ын тайлангаа аудитаар баталгаажуулсан бол 205 компани нь санхүүгийн нэгдсэн тайлангаа аудитаар баталгаажуулсан байна. Засгийн газрын тайлангийн дүнгүүд баталгаатай эсэх тодорхойгүй байсан хэдий ч тулгалтын явцад 5879 тэрбум болж баталгаасан байна.

Тайланд уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын мэдээг оруулж холбогдох дүгнэлтийг танилцуулсан байна.

### **Компаниудын оролцоо**

Нэгтгэлд компаниудын оролцоо өмнөх жилүүдээс сайн байсан хэдий ч зарим компаниуд тухайлбал, Монголболгаргео, Бужгар орд, Угалзан цамхагкомпаниуд хариу өгөлгүй ажлыг саатуулсан байна.

### **Засгийн газрын байгууллагуудын оролцоо**

Засгийн газрын байгууллагуудын оролцоо хангалттай түвшинд байсан хэдий ч Гаалийн ерөнхий газар, Баянгол, Сүхбаатар дүүргийн татвар, Чигэлтэй, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгал, Сонгинохайрхан дүүргийн өмч, газрын харилцааны газар хэлтсүүд хариу өгөлгүй хөшүүн хойрго ханджээ.

### **Монголын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэл тайлангийн зөвлөмжүүд**

1. Засгийн газрын мэдээлэл цуглуулах процессийг ажлын цар хүрээнд оруулан хараат бус нэгтгэгчид тайлан бэлтгэн өгдөг голлох яамдыг харгалзан үзэж, шалгах;
2. Нэгтгэл орох компаниудыг сонгох аргачлалыг боловсронгуй болгох;
3. Нэгтгэлд орох компаниудын тоог багасгах, тэргүүлэх компаниудыг өргөнөөр хамруулах
4. Нэгтгэлд орох компанийн тоо, цар хүрээний судалгааг явуулах;
5. Засгийн гарьяа байгууллагуудын тайланд ахлах ажилтнууд гарын үсэг зурж баталгаажуулах, Үндэсний аудитын газраар баталгаажуулж байх;
6. Компаниудын хувьд удирдлагын хариуцлагын мэдэгдлийг давхар гаргаж байх;
7. Гэрээний ил тод байдлыг хангах яаралтай арга хэмжээ авч ажиллах, гэрээний мэдээллийн нэгдсэн сан бий болгох;

8. Сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

### **1.3 Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан гаргах аудитын консерциумыг сонгон шалгаруулсан нь**

Монголын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан гаргах аудиторын консерциум шалгаруулах удирдамжийг 2014 оны 3 дугаар сарын эхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас батлуулж, Үнэлгээний хороог байгуулсан байна. Удирдамжийг боловсруулахад Монголын ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүдийг оролцуулж, цахим сүлжээг ашигласан бөгөөд эцэст нь Үнэлгээний хорооноос нэмэлт өөрчлөлт оруулж, ОУИТБС-ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудыг оруулсан байна.

Сонгон шалгаруулалтыг 2014 оны 3 дугаар сараас эхлэн явуулж, сонгон шалгаруулалтыг 5 дугаар сарын эцсээр дуусгаж, Улаанбаатар аудит, Харт Нойрс Монгол/Их Британи улсын консерциумшалгарсан боловч Их Британийн Мооре Стефенс, Монголын Далайван аудит компаниудын консерциум гомдол гаргасан байна. Гомдлын агуулга нь техникийн саналын үнэлгээнд эргэлзэж байгаагаа илэрхийлж, дахин үнэлгээ хийж өгөхийг хүссэн байна. Гомдлоо албан ёсоор гаргаагүй учир үнэлгээг дуусгаж Улаанбаатар аудит, Харт Нойрс Монгол/Их Британи улсын консерциумтай гэрээ байгуулж, ажлыг нь 8 дугаар сард эхлүүлж, 12 дугаар сард дуусгасан байна.

### **1.4 Компани болон Засгийн газрын ОУИТБС-ын 2013 оны тайлан гаргах ажлыг зохион байгуулсан нь**

ОУИТБС-ын ажлын алба Ашигт малтмалын газартай хамтран ажиллаж, сургалт зохион байгуулж, сонин, цахим сүлжээгээр сурталчилгаа хийж ажилласаны үр дүнд ашигт малтмалын 1188, газрын тосны 8, ураны 2 компани, нийт 1198 орчим компани 2013 оны тайлангаа 2014 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөр гаргасан байна.

Засгийн газрын ОУИТБС-ын 2013 оны тайланг гаргах асуудлаар Ажлын алба зохих байгууллагуудтай хамтран ажиллаж, Засгийн газрын тайланг 5 дугаар сарын 12-нд 1617 компаниар гаргуулсан байна.

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн үнэмлэхүй олонхийг хамруулж чадсан байна.

Компани, Засгийн газрын байгууллагуудаас ОУИТБС-ын тайлангаа гаргахад нь дэмжлэг үзүүлж, 3 дугаар сард хамтад нь тайланг гаргахад анхаарлын асуудлаар өргөн бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд Далайван аудит компанийн аудиторуд оролцож, зөвлөгөө өгсөн байна. Сургалтад 78 хүн хамрагдсан байна.

### **1.5 ОУИТБС-ын тайлагнал, шинэлэг алхам**

Тайланг гаргаж, нэгтгэл тайланд орж байгаа компаниудын тоо жил бүр нэмэгдэж, зөрүү жил бүр буурч байна.

Он	Тайлан гаргасан компани	Сангийн яамнаас гаргасан Засгийн газрын тайланд хамрагдсан компанийн тоот	Монгол Улсын нэгтгэл тайланд орсон компани	Тайлбарлагдаагүй зөрүү
2006	64	137	25	4 тэрбум төгрөг

2007	102	184	38	775 сая төгрөг
2008	115	184	46	425 сая төгрөг
2009	129	363	101	58 сая төгрөг
2010	274	477	150	360 мянган төгрөг
2011	301	518	200	75 сая төгрөг
2012	1529	1829	200	360 сая төгрөг
2013	1198	1617	250	36 сая төгрөг

Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлангийн хүрээнд олборлосон, борлуулсан эрдсийн түүхий эд, ашигт малтмалын бүтээгдэхүүний тоо хэмжээ, уулын ажлын төлөвлөгөөний биелэлт, тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний талаар тойм судалгааг нэгтгэл орсон компаниудаар гаргасан байна.

### 1.6 Олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаа

#### Орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд:

2014 оны 4 сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо 21 аймгийн дэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарыг урьж “Үр дүнд чиглэсэн дэд зөвлөлийн үйл ажиллагаа” сэдэвт олон талт оролцогчдын зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнөөр аймаг бүрийн 2014-2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл, санхүүжүүлэх боломжит хувилбаруудыг хэлэлцэж, санал солилцов. Аймаг бүр төлөвлөгөөний төслийг дахин хянан, боловсруулж ажлын албанд ирүүлэхээр тогтов. Зөвлөгөөнд 65 хүн оролцсоны 40 нь 19 аймгийг төлөөлсөг ба түүний 9 нь аймгийн Засаг даргын орлогч, 13 нь газар, хэлтсийн дарга буюу удирдах ажилтнууд байв. Аймгийн дэд зөвлөлүүд 2014-2015 оны ажлын төлөвлөгөөтэй болсон байна.

Сумын түвшинд салбар зөвлөл байгуулах ажлыг хэрэгжүүлсэн байна. Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтэций сумдын салбар зөвлөлийг идэвхжүүлэх, Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай, Баянхонгор аймгийн Галуут, Дархан-Уул аймгийн Шарынгол сумдад ОУИТБС-ын салбар зөвлөл байгуулаад байна.

дд	Аймаг	Сум	Өдөрлөг зохион байгуулсан огноо	Оролцогчдын тоо
1	Төв	Заамар	5 сарын 08	52
2	Булган	Бүрэгхангай	9 сарын 23	95
3	Баянхонгор	Галуут	9 сарын 25	43
4	Хэнтий	Норовлин	10 сарын 07	66
5	Дорнод	Баяндун	10 сарын 08	88
6	Дундговь	Баянжаргалан	10 сарын 28	46
7	Дорноговь	Даланжаргалан	10 сарын 29	77
8	Дархан-Уул	Шарын гол	11 сарын 12	102
9	Сэлэнгэ	Баянгол	Хойшлогдсон	-
10	Орхон	Эрдэнэт	11 сарын 14	50
			Нийт	619

Нийт 9 удаагийн арга хэмжээнд орон нутгаас 619 хүн оролцож, Төв аймгийн Заамар, Дундговь аймгийн Баянжаргалан, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын өдөрлөгийг Ийгл ТВ бүрэн эхээр, Булган аймгийн Бүрэгхангай сумын өдөрлөгийг сумын удирдлага өөрийн санаачлагаар

Эко ТВ- тэй хамтран бүрэн эхээр, Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Орхон аймгийн Эрдэнэт хотын өдөрлөгийг орон нутгийн ТВ-үүд сурвалжилж олон нийтэд мэдээлсэн болно.

Өдөрлөгт зориулж зөвхөн тухайн сумын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын лавлах ном” бэлтгэн, сум бүрт 300 ширхэг, нийт 2700 ширхэг ном хэвлүүлж сум, баг, иргэдэд тараав. Тухайн сумын иргэдэд олборлох үйлдвэрлэл хир ил тод, нээлттэй байгаа, мэдээллийн хүртээмж, чанарыг судлах үүднээс асуулгын хуудас боловсруулж, 5 сумаас судалгаа авч ажиллаа. Томилолтоор ажилласан сум бүрт ОУИТБС-ын салбар зөвлөл байгуулах тухай зөвлөмж, чиглэлийг өгсөн бөгөөд өнөөдрийн байдлаар Төв аймгийн Заамар, Баянхонгор аймгийн Галуут, Дархан-Уул аймгийн Шарын-гол суманд ОУИТБС-ын салбар зөвлөл байгуулсан тухай шийдвэр, тогтоолоо ажлын албанд ирүүлээд байна.

Сумаас суманд ажиллахдаа өмнө нь олж авсан сургамжиндаа тулгуурлан үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох үүднээс засч, сайжруулан, сайн туршлагыг боловсронгуй болгоход анхаарч ажиллав. 9 аймгийн 9 сумыг 5 чиглэлд хуваан, нэг удаагийн томилолтоор 2 суманд олон талт-хэлэлцүүлэг- өдөрлөгийг зохион байгуулж, нийт 20 гаруй хоног орон нутагт ажилласан байна. Сум бүр харилцан адилгүй, өөр өөрийн онцлогтой, давуу, сул талууд ажиглагдаж байв. Гэхдээ ажлын тайланг талуудын оролцоо, хөтөлбөрийн агуулга, чанар, мэдээллийн хүртээмжтэй байдал, тухайн сумын нөхцөл байдал, салбар зөвлөл байгуулахад анхаарах асуудлууд гэсэн 5 үзүүлэлтээр тоймлон дүгнэв.

Нийслэлийн дэд зөвлөлтэй хамтран Налайх дүүрэг болон Улаанбаатар хотод 2 удаагийн сургалт зохион байгуулж элс хайрганы олборлолтын компаниудыг хамруулсан.

Улаанбаатар хотод зохион байгуулсан “Их 7-ийн үр дүнд түргэн хүрэх түншлэл” олон улсын бага хурал, УИХ-ын ЭЗБХ, УУЯ, ТАН эвсэл, МУУҮА, ННЦ, Ажлын алба хамтран зохион байгуулсан “Гэрээний ил тод байдал” хэлэлцүүлэгт орон нутгийн дэд зөвлөлөөс төлөөлөл оролцуулж чадавх бэхжүүлсэн.

### **Хэвлэл, мэдээлэл, олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд:**

2014 оны 2 сарын 12-нд Төрийн ордонд 2012 оны нэгтгэл тайлан баталсан тухай хэвлэлийн бага хурлыг зохион байгууллаа.

Харилцааны стратегийн дагуу олон нийтэд мэдээлэх ажлыг сайжруулах зорилгоор Монгол Масс медиа групптай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Ийгл ТВ-ээр мэдээ нэвтрүүлэх, 12 удаагийн цуврал нэвтрүүлэг бэлтгэх, цацах, [www.news.mn](http://www.news.mn) сайтад мэдээ байршуулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Өдөр тутмын сонинд тайлан гаргасан болон гаргаагүй компаниудын нэрс, 2013 оны тайлагналын явцын талаар болон ОУИТБС-ын талаар нийтлэл хэвлэл нийтлүүлж байна.

Блүүмбэрг, ТВ9, ТВ8, Ийгл ТВ, Эко ТВ, зарим өдөр тутмын мэдээллийн цахим хуудсанд мэдээ байршуулж байна.

Монгол Улсад зохиогдсон олон улсын болон нийтийг хамарсан зарим арга хэмжээнүүдэд тогтмол оролцож байна. “Уул уурхайн яамны нээлттэй өдөрлөг”-т оролцож ОУИТБС-ын тухай танилцуулга хийж, үзэсгэлэн гаргаж хэвшлээ.



Ажлын албаны цахим хуудсыг хэрэглэгчдэд илүү ойр, хэрэглэхэд ойлгомжтой болгон шинэчлэн сайжруулж байна. Ингэснээр цахим орчинд сошиал мэдиагаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хийх бэлтгэлийг хангаж байна.

Танилцуулах материал, тараах зурагт хуудасны агуулгыг шинэчлэн хэвлүүлсэн.

#### **Дотоод харилцаа, холбоог сайжруулах хүрээнд:**

Сургагч багш нарт зориулж мэдээллийг шуурхай солилцох, туршлага хуваалцах зорилго бүхий facebook бүлгийг нээж, ажиллуулж байна.

2014 оны 6 дугаар сараас эхлэн Ажлын хэсэг, дэд зөвлөлийн гишүүд, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, компаниуд, төр засгийн байгууллагуудын төлөөлөлд ОУИТБС-ын сар бүрийн цахим сонин, мэдээг хүргүүлж байна.

#### **Гадаад арга хэмжээний хүрээнд:**

Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон 10 дугаар сард Мьянмар улсад зохиогдсон зохицуулагчдын уулзалтад оролцож, шинэ стандартын дагуу хийгдэж байгаа үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн.

### **ХОЁР. ОУИТБС- ЫН ШААРДЛАГУУДЫГ ХАНГАСАН БАЙДАЛ, ЯВЦ**

2.1. ОУИТБС- ын стандарт 2013 онд шинэчлэн батлагдаж гишүүн орнууд ОУИТБС- ыг өргөжүүлэх талаар томоохон үүрэг амлалт авсан байна. Үүний адил Монгол Улс холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

#### **Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголт шаардлага 3.9, 3.10**

Нэгтгэлд хамрагдсан компаниудын бүртгэл, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын мэдээг тус тусад нь гаргаж, мэдээг ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, талбайн хэмжээ, олгосон огноо, хүчинтэй байх хугацаа, аймаг, сум, дүүрэг, талбайн нэрийн хамт гаргасан байна.

Дэлхийн Банкны техникийн туслалцааны хөтөлбөрийн дэмжлэгээр Ашигт малтмалын газар (АМГ)-аас 2014 онд нэвтрүүлсэн Уул уурхайн Кадастрын Цахим Систем (УКЦС) нь ашигт малтмалын салбарт олгогдсон лицензүүд, тэдгээрийн газар нутгийн хамрах хүрээ мөн лиценз олгохтой холбоотой зарим дүрэм журам, баримт бичгийг нийтэд нээлттэйгээр интернэтэд байршуулжээ. Ашигт малтмалын газраас уул уурхайн компьютержсэн кадастрын уг системийг олон нийтийн хүртээл болгож, өөрсдийн албан хэрэгцээнд ашиглаж, шинэчлэж байна. Нэвтрэх хаяг <http://cmcs.mram.gov.mn/CMCS#cid=1>

Энэ систем нь олон нийтэд тусгай зөвшөөрөлд хамрагдсан газар, ТЗ- ын дугаар, өөрчлөлтийн дугаар, газрын нэр, төрөл, бүртгэлийн байдал, эзэмшигч, өргөдөл гаргагчийн нэр, талбайн хэмжээ, огтлолцол мөн тусгай хэрэгцээний газрын бүртгэл, түүний бүртгэлийн дугаар, нэр, төрөл, зориулалт зэрэг олон тооны мэдээллийг харуулахаас гадна төрөл бүрийн маягтуудыг байршуулсан байна.ж байна.

Харин газрын тос, хийн салбар болон цацраг идэвхит ашигт малтмалын салбарт олгогдсон лицензүүдийн мэдээллийг эдгээр салбаруудыг хариуцдаг Газрын Тосны Газар (ГТГ), Цөмийн

Энергийн Газар (ЦЭГ)-ууд нийтэд ил болгоогүй байна. -62- 69- р хуудас болон 13 дугаар хавсралт

### **Бенефициар өмчлөл 3,11**

Монгол Улсад энэ чиглэлээр эрх зүйн орчинд зарим хуулийн тодорхойгүй заалт, хоорондын зөрчлийн улмаас өмчлөлийг ил болгох явдлыг тойрч гарах орон зай байсаар байна. Холбогдох хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан ч одоо л хэлэлцэгдэж байна.

Гэвч Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэл тайланд 250 компаниас 216 компанийн хувьцаа эзэмшигч, тэдгээрийн албан тушаал, 5 болон түүнээс дээш хувь хэмжээтэй хувь хүмүүсийн нэрсийг ил тод болгосон байна. -22 дугаар хавсралт

### **Гэрээний ил тод байдал 3,12**

Гэрээний ил тод байдлыг Монгол Улс дэмжиж байгаа ч одоо болтол ямар арга замаар ил тод болгох талаар нэг мөр ойлголттой болоогүй байна. Тухайлбал Уул уурхайн яам, Газрын тосны газрын хооронд бүтээгдэхүүн хуваах гэрээний нууцлалын асуудлаар 2 өөр байр суурьтай байна. Харин Оюутолгой төсөлтэй холбоотой гэрээнүүд харьцангуй ил тод болсон.

Ашигт малтмалын тухай хуулийн 42,1- д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчид нутгийн удирдлагатай гэрээ байгуулж, хамтран ажилладаг. Нэгтгэл тайлангийн судалгаагаар 2013-2014 онд нийтдээ 153 гэрээг орон нутгийн Засаг даргын тамгын газартай байгуулсан байна. Үүнээс 22 нь хамтран ажиллах, 27 нь нийгмийн хариуцлагын гэрээ, 37 нь орд ашиглах гэрээ, 9 нь байгаль орчиныг нөхөн сэргээх гэрээ байжээ. -114 дүгээр хуудас болон 14 дүгээр хавсралт

### **Санхүүгийн жилийн үйлдвэрлэлийн мэдээлэл 3,5**

Ашигт малтмалын газраас нийтэд зориулж сар бүр статистик мэдээллийг цахим хуудас дээр байршуулж байна. Статистик мэдээлэл нь тусгай зөвшөөрлийн мэдээлэл, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, хөрөнгө оруулалт, эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт, улсын төсвийн болон хувийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажил болон нөөцийн судалгааг хэвлэн нийтэлж байна. Мөн Уул уурхайн яамны жилийн жил бүрийн тайлангуудаар эдгээр мэдээллийг хэвлэн нийтэлж байна. [http://www.mram.gov.mn/index.php?option=com\\_content&view=category&id=65%3A2013-05-16-00-47-34&layout=blog&Itemid=20&lang=mn](http://www.mram.gov.mn/index.php?option=com_content&view=category&id=65%3A2013-05-16-00-47-34&layout=blog&Itemid=20&lang=mn)

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд санхүүгийн жилийн үйлдвэрлэлийн мэдээлэл эдгээр мэдээллүүд дэлгэрэнгүй байдлаар орсон болно.-28-60 дугаар хуудас

### **Хуулийн орчин, санхүүгийн нөхцөл байдал 3,2, салбарын эдийн засгийн нөлөө, 3,4, орлогын хуваарилалт, дэд бүтэц, бараа материалын солилцоо гэх мэт мөнгөн бус орлого 4.1**

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд санхүүгийн жилийн үйлдвэрлэлийн мэдээлэл эдгээр мэдээллүүд дэлгэрэнгүй байдлаар орсон болно.-28-60- р хуудас

### **Төрийн өмчийн компаниудын төлбөр ба шилжүүлэг 4,2, төсвийн бус зардал**

Уул уурхайн салбарт төрийн болон төрийн өмчийн оролцоотой 99 аж ахуйн нэгж байна. Хамтарсан хувьцаат 100 хувийн төрийн өмчийн компани 47, төрийн өмчийн хязгаарлагдмал хариуцлагатай компани 7, төрийн өмчит үйлдвэр 25, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 4, хамтарсан үйлдвэр 5, бусад 11 байгааг тайлангаар тодорхой болгож өгсөн. Олон улсын

шаардлагын дагуу төрийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн судалгааг гаргасан байна. -48-56- р хуудас болон 15 дугаар хавсралт

#### **Орон нутагт хүлээн авсан шууд төлбөр, шилжүүлэг 4,2**

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд орон нутгийн төлбөрүүдийн мэдээг 20 дугаар хавсралтаар нэгтгэлд орсон компаниудын түвшинд гаргасан байна.

#### **Ажил олголт 3,4**

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд ажил олголтын мэдээг 43-44 дүгээр хуудсанд болон 21- р хавсралтад оруулсан байна.

#### **Нийгмийн зардал 4,1**

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд нийгмийн зардлын мэдээг 19 дүгээр хавсралтаар бүхэлд нь харуулсан байна.

#### **Орлогын хуваарилалт 3,7, 3,8**

Монгол Улсын ОУИТБС- ын 2013 оны нэгтгэлд орлогын хуваарилалтын танилцуулгыг 56-60 дугаар хуудсанд харуулсан байна.

#### **Цахим тайлагнал 5,3**

Цахим тайлагналын системийн танилцуулгыг 2 удаа, системийн туршилтыг хоёр удаа зохион байгуулсан. Мөн цахим тайлагналын системийн сургагч багшийн сургалтыг зохион байгуулж төрийн байгууллагын 6, компанийн 6, иргэний нийгмийн төлөөлөл 6 хүн тус тус хамрагдсан.

### **ГУРАВ. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН ХЭСГЭЭС ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОЙМ**

#### **3.1.Үндэсний зөвлөлийн хуралдаан**

Монголын ОУИТБС- ын Үндэсний зөвлөл 2014 онд хуралдаж чадаагүй байна.

#### **3.2.Ажлын хэсгийн хуралдаанууд**

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ээлжит хуралдаанууд 2014 онд 2 удаа зохиогдож, ирц 70 орчим хувьтай байсан.

#### **3.3.ОИТБС-ын тухай хуулийн төслийг боловсруулж байгаа нь**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үзэл баримтлал болон хуулийн төсөл боловсруулж, Хууль зүйн яаманд оруулж, үзэл баримтлалыг 2014 оны 5 дугаар сард батлуулсан байна.

Хуулийн төсөлд ОУИТБС- ын 2013 оны шинэ стандартын шаардлагуудыг бүхэлд нь оруулсан бөгөөд өөрийн улсын онцлог болох орон нутгийн дэд, салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар зохих хуулийн томъёолол, санхүүжилт, зохион байгуулалтын бүтцийг оруулсан байна. Хуулийн

төслийн нэрийг “Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хууль “ болгон өөрчилж, төслийг 2014 оны 9 дүгээр сарын Засгийн газрын хурлаас дэмжин, УИХ-ын намрын чуулганд хуулийн төслийг 10 дугаар сард өргөн барьсан байна.

### **3.4.ОУИТБС-ын санхүүгийн тогтвортой эх үүсвэрийн тухай**

Монгол Улсын Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжүүлэх ажлын санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах үүднээс нэгтгэл тайлангийн санхүүжилтийг 2010 оноос эхлэн улсын төсвөөс санхүүжүүлж байгаа бөгөөд 2012 онд 201,1 сая төгрөг, 2013 онд 183 сая төгрөг зарцуулж, 2014 онд 220,1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөөтэй болно. Эдгээр төсвийн хөрөнгийг ихэнхи хэсгийг жил бүрийн нэгтгэл тайланг боловсруулахад зарцуулж байна.

Ажлын албаны санхүүжилт Дэлхийн банкны итгэлийн сангийн төслөөр хэрэгжиж байна. Санхүүжилтийн хувьд 2014 оны 5 дүгээр сард дуусч, дараагийн 280,000 ам.долларын төслийг 9 дүгээр сард эхлүүлэхээр төлөвлөж байсан ч өнөөг болтол орж ирээгүй байна.

Иймд ОУИТБС-ын олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас 46450 ам.долларын санхүүжилтийг 2014 онд дуустал олгосон байна. .

### **3.5. Мэдээллийн технологийн зөвлөхийг авч ажиллуулсан нь**

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр мэдээллийн технологийн зөвлөхөөр Г.Ганбатыг ажлуулж эхлэв. Тэрээр холбогдох мэргэжилтэн, гүйцэтгэгч компанийн хамт цахим тайлагналын системийг 5-8-р саруудад боловсруулаад 2015 оны 1-р сараас хэрэгжүүлэхэд бэлэн болсон.

## **ДӨРӨВ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН БАЙДАЛ**

4.1. 2014 онд нийт 65 үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 42 үйл ажиллагааг хэрэгжүүлж, биелэлтийн хувь 65 орчим болсон.

4.2. Хэрэгжүүлж чадаагүй гол ажил нь ОУИТБС-ын хуулийн төслийг батлуулахтай, бүсчилсэн бага хурлууд, телевизийн нэвтрүүлэг зохион байгуулах ажил байсан. Хуулийн төслийг чанартай хийх зорилгоор хугацаагаа нарийн баримтлахгүй ажилласны үр дүнд хуулийн үзэл баримтлал, төслийг Хууль зүйн яамаар 2014 оны 3 дугаар сард батлуулсан байна. Төслийн санхүүжилт 2014 оны 6-9 дүгээр хүртэл саатснаас нилээд олон ажлыг зохион байгуулж чадалгүй хойшлуулсан байна.

## **ТАВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ**

### **ОУИТБС-ын үйл явцын талаархи Ажлын хэсгийн дүгнэлт**

5.1. Монгол Улсын ОУИТБС-ын 8 удаагийн нэгдсэн тайланг гаргаж, тайлангаас тайланд хамрагдаж байгаа компанийн тоо нэмэгдэж, аудитын нэгтгэлээр гарч байгаа зөрүү багасч байна. Монгол Улсын татвар, төлбөрийн ил тод байдлыг хангах төдийгүй ОУИТБС-ын хүрээнд хэд хэдэн шаардлагуудыг нэмж хамруулж, тайланд тусгаад байна. Онцлон тэмдэглэхэд ОУИТБС-ыг хэрэгжүүлж байгаа стратеги, ажлын төлөвлөгөө уян хатан, оролцогч талуудын оролцоог хангасан байдлаар хэрэгжиж байгаа нь дээрх ололт амжилтын гол тулгуур болж байна.

5.2. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд Засгийн газар, компаний, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, санаачлага сайн байна.

5.3. Монгол Улсад ОУИТБС тогтвортой хэрэгжиж байгаа ч хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдал, саатал, хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас улбаалан томоохон шинэчлэл, өөрчлөлтийг хийх бололцоо дутмаг байгааг хүлээн зөвшөөрч байна. Хууль эрх зүйн байдал тодорхойгүйгээс гарган зөрүүг шийдвэрлэхэд хүндрэл үүсгэж байна.

5.4. Мөн сургалт сурталчилгааны чиглэлээр ихээхэн хүчин чармайлт, цаг хөрөнгө гаргах нь зайлшгүй болжээ. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын албан хаагчид, удирдлагууд, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, төлөөлөгчид болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл мөн орон нутгийн иргэдийг сургалтад хамруулах, компанийн санхүүгийн ажитнуудад зориулсан сургалтын чанарыг сайжруулах, тайланг ойлгомжтой хэлбэрээр орон нутгийн иргэдэд хүргэж сурталчлах, энэ чиглэлээр оновчтой бүтэц, зохион байгуулалт бий болгож чадаагүй байна.

5.5. Шинэчлэл, сайн засаглалын хүрээнд Монгол Улс хууль баталж, төсвийн хууль, түүний ил тод байдлыг хангасан байх зарчмыг тодорхойлж, төсвийн бүх явцад олон нийтийг оролцуулах, саналыг авах, харгалзан үзэх, хяналт тавих боломжоор хангах, тэдэнд мэдээлж байхыг хуульчилж өгсөн.

Мөн уг хуулиар зөвхөн эмнэлэг, бүх шатны боловсрол, соёлын үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив дэмжлэг авч болно. Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиасхэтрэхгүй байна.

Санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсан хөтөлбөр, арга хэмжээг үргэлжлүүлэх; байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх тохиолдолд төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эдхөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно:

Төсвийн байгууллага хандив, тусламж авахыг хориглох тохиолдол нь хандив, тусламж өгсөн этгээд нь төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх зэргээр шийдвэрлэгдсэн байна.

5.6. Монгол улсад дараахь хуулийн заалтуудаар ОУИТБС-ын тайлан гаргахыг компаниудад үүрэг ногдуулаад байна Үүнд: 2006 онд батлагдсан Ашигт малтмалын хуулийн 48.10, 2009 онд батлагдсан Цөмийн энергийн тухай хуулийн 28.6.4, 2014 онд батлагдсан “Газрын тосны” тухай хуулийн 36.1, мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34.10 тоот заалтуудын дагуу олборлох үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч урд онд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн тайлангаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээний хамт дараа оны нэгдүгээр улирал дуусахаас өмнө гаргаж нийтэд мэдээлнэ гэж хуульчилсан байна. Эдгээр заалтуудын дагуу тайлан гаргаж буй компаниудын тоо жилээс жилд өсч байна.

5.7. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 тогтоолыг сурталчилах, түүнийг үр бүтээлч сурталчлах чухал ажлын суваг нь Монгол Улсад ОУИТБС-ын хэрэгжилтийн байдлыг УИХ-д, эсхүл байнгын хороонд танилцуулах ажил бөгөөд энэ ажлыг Үндэсний зөвлөлөөс зохих гаргуулсны үндсэн зохион байгуулах хэрэгтэй байна.

5.8. Монгол Улсын УИХ “Шилэн дансны тухай” хуулийг 2014 онд батлаж, төсвийн орлогын зарцуулалтад олон нийтээс тавих хяналтыг боломжтой болгож байна. Уг хууль 2015 оны 1 дүгээр сарын 1- нээс хэрэгжиж эхлэнэ.

5.9. ОУИТБС- ын хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсад шинэчлэлийн шаардлагыг ухамсарлан Улсын Их хурал 2014 оны 1 дүгээр сард “Төрөөс эрдэс баялагийн салбарт 2014-2025 он хүртэлх баримтлах бодлого”- ыг баталсан байна. Бодлогын гол үндэслэл нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ. Бодлогоор чухал зарчимуудын тодорхойлсны нэг нь эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж нээлттэй, ил тод, хариуцлагатай байх явдал гэжээ.

2025 он хүртэлх бодлогод эрдэс баялгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ил тод байдлын болон хариуцлагатай уул уурхай, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ зэрэг олон улсын санаачилгыгдэмжин хөгжүүлнэ гэж заасан байна.

## **ЗУРГАА. ТАЙЛАНГ БОЛОВСРУУЛСАН, БАТАЛСАН ОГНОО 2014 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР**